

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт,
үр нөлөө, үр дүн

АУДИТЫН КОД: ТӨА-2022/30-17-ШТА-ГА

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Жаргалсайхан

Утас: 70273465 Цахим хаяг: jargalsaikhanl@audit.gov.mn

Аудитор Ч.Загдсүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: zagsurench@audit.gov.mn

Аудитор Г.Сугармаа

Утас: 70273465 Цахим хаяг: sugarmaag@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273463 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

| | |
|---|-----|
| Товчилсон үгийн тайлбар..... | 3 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл..... | 4-5 |

| | |
|--|------|
| Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна..... | 6 |
| 1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилж байгаа боловч сумдын хувьд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, малын тоо толгойн албан татварыг огт төлөвлөхгүй байна..... | 6-9 |
| 1.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг авах ажил холбогдох журмын дагуу хийгдэхгүй байна..... | 9-13 |

| | |
|---|-------|
| Бүлэг 2. Аймгийн хэмжээнд 2021 онд ОНХС-аас хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл 62.5 хувьтай байгаагаас сумын гүйцэтгэл 38 хувьтай хэрэгжсэн байна..... | 14 |
| 2.1.ОНХС-аас хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын захиалагч нь ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчиж гэрээ байгуулан, хэрэгжүүлсэн байна..... | 14-18 |
| 2.2. Аймгийн хэмжээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжлийн бодлого болон иргэдийн саналаар эрэмбэлэгдэж, хэрэгжиж байгаа нь тухайн орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлж байна..... | 18 |
| 2.3 Хөрөнгө оруулалтын ажил нь хугацаандаа хэрэгжээгүйгээс үр дүн, үр өгөөжгүй болж, тухайн ажилд зарцуулсан санхүүжилтийн үр дүнд бий болсон хөрөнгө эвдэрч муудан, ашиглалтгүй болж байна..... | 18 |

| | |
|---|-------|
| Бүлэг 3. ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд мэдээлэл оруулах ажил хангалтгүй, түүнд тавих хяналт байхгүй байна..... | 19 |
| 3.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад СХДАА-аас жил бүр хяналт тавьж ажилласан байна..... | 19-20 |
| 3.2 Аймгийн ХОХБТХ-т сумдын ЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг ирүүлж нэгтгүүлэн Сангийн яаманд хүргүүлэх ажил хэрэгжихгүй байна..... | 20-21 |

ДҮГНЭЛТ:.....22

ЗӨВЛӨМЖ:.....23

ХОЛБОГДОХ БАЙГУУЛАГЫН САНАЛ:.....24-25

Товчилсон үгийн тайлбар

| | |
|--------------|--|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АМНАТ | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр |
| БЗОСК | Барилга захиалагч, орон сууц корпорац |
| БИНХ | Багийн Иргэдийн нийтийн хурал |
| ДЭХГ | Дулааны эрчим хүчний газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| НАТ | Нөөц ашигласны төлбөр |
| НТШ | Нээлттэй тендер шалгаруулалт |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| СХДАА | Санхүү хяналт, дотоод аудитын алба |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай |
| ХБТХОХ | Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| ХОХБТХ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /ХБТХОХ-ийн тухайн үеийн нэр/ |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

| | |
|--|---|
| | <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> |
| <p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p> | <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.</p> |
| <p>Аудитын зорилт</p> | <p>“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; ▪ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; ▪ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх. |
| <p>Аудитын хамарсан хүрээ</p> | <p>Аймаг болон 27 суманд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хамрууллаа.</p> |
| <p>Аудитын хязгаарлалт</p> | <p>Байхгүй</p> |
| <p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p> | <p>Аудитыг АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит.</p> |

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2021 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн, Г.Сугармаа, Б.Нямсүрэн нар гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 04-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хүртэл гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилж байгаа боловч сумдын хувьд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, малын тоо толгойн албан татварыг огт төлөвлөхгүй байна.

ОНХНС-ийн эх үүсвэрийг НӨАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хайгуул хийх, олборлолт хийх тусгай зөвшөөрлийн орлого зэрэг орлогоос Төсвийн тухай хуульд заасан хувиар тооцож бүрдүүлж байна. Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”, Сангийн сайдын 2016 оны 17 тоот тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын дагуу сангийн хөрөнгийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилж байна.

Төв аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн гуравдугаар хуралдааны 03 тоот тогтоолоор ОНХНС-аас авах санхүүжилт 9,068.8 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 600.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээр 1,050.0 сая төгрөг, нийт 10,718.8 сая төгрөгөөр баталсан. УИХ-аас 2021 оны төсвийн тухай хуульд тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит бус хоёрдугаар хуралдааны 01 тоот тогтоолоор ОНХНС-аас авах санхүүжилт 9,333.7 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 216.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээр 1,050.0 сая төгрөг, нийт аймгийн ОНХС-ын 2021 оны эх үүсвэрийг 10,599.7 сая төгрөг болгон тодотгон баталсан байна.

Төв аймагт ОНХНС-аас олгох 9,333.7 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1¹, 59.1.2², 59.1.5³-д заасан орлогоор 4,971.5 сая төгрөг, 59.1.3⁴-д заасан дэмжлэг, урамшууллаар 454.4 сая төгрөг, 60 дугаар зүйлийн 60.2.6⁵-д заасан орлогоор 2,566.1 сая төгрөг, 60.2.7⁶-д заасан орлогоор 1,341.7 сая төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Хүснэгт 1: ОНХНС-с олгох аймгийн ОНХС-нд олгох орлого /сая.төг/

| Орлого ТТХ-ийн заалт | Дотоодын НӨАТ 59.1.1 | Газрын тосны НАТ 59.1.5 | АМНАТ 59.1.2 | АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 60.2.7 | АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 60.2.7 | АМНАТ-Мега төслүүдээс хассан зөрүүний /10 хувь / 60.2.6 | ОУ-ын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС-д олгох урамшуулал 59.1.3 | ОУ-ын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС-д олгох дэмжлэг 59.1.3 | Нийт |
|----------------------|----------------------|-------------------------|--------------|--|---|---|---|--|---------|
| Төв аймаг | 1,552.1 | 288.2 | 3,131.2 | 331.8 | 1,009.9 | 2,566.1 | 333.1 | 121.3 | 9,333.7 |

Эх сурвалж: СТСХ-ээс ирүүлсэн судалгаа

¹ импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь;

² Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь;

³ Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

⁴ Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

⁵ Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь

⁶ Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.5-д заасан орлогыг өмнөх сарынхыг дараа сард нь, 60 дугаар зүйлийн 60.2.6, 60.2.7-д заасан орлогыг улирлаар тооцон ОНХНС-аас аймгийн ОНХС-нд олгож байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.5-д заасан дотоодын НӨАТ, газрын тосны НАТ, АМНАТ-ийн орлого сар бүр харилцан адилгүй байдаг хэдий ч Сангийн яам батлагдсан төсвийн хуваарийг баримтлан санхүүжилтийг олгож байна. Сангийн яамны ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн санхүүжилтийн эрх олгосон баримтаас үзэхэд Төв аймагт хуваарилагдах дээрх 3 төрлийн орлогоор 2021 онд 5,492.3 сая төгрөг орж, 4,971.5 сая төгрөг олгосон байна.

Хүснэгт 2: Төсвийн орлого, санхүүжилтийн харьцуулалт /сая.төг/

| Үзүүлэлт | Төсвийн орлого | | | |
|---------------------------|----------------------|-------------------------|--------------|---------|
| | Дотоодын НӨАТ 59.1.1 | Газрын тосны НАТ 59.1.5 | АМНАТ 59.1.2 | Нийт |
| Төсвийн орлого | 1,533.5 | 1,887.8 | 2,070.9 | 5,492.3 |
| Олгосон санжүүжилт | 1,552.1 | 288.2 | 3,131.2 | 4,971.5 |
| зөрүү орлогоос | (18.5) | 1,782.7 | (1,060.3) | 520.8 |

Эх сурвалж: СТСХ-ээс ирүүлсэн судалгаа

Газрын тосны НАТ-орлогоор 1,887.8 сая төгрөг орж, 288.3 сая төгрөг олгосон бол АМНАТ-аар 2,070.9 сая төгрөг орсон байхад 3,131.2 сая төгрөг олгожээ. Нийт дүнгээр нь авч үзвэл 3 төрлийн орлогоор Төв аймагт хуваарилагдах дүн нь батлагдсан төсвийн хуваариас 520.7 сая төгрөгөөр давсан байна.


Аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолоор Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-д заасны дагуу болон холбогдох журам аргачлалын дагуу аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-нд олгох шилжүүлгийг тооцож баталж байна.

Сумдын ОНХС-нд 2021 онд 3,374.5 сая төгрөг олгохоор батлагдсаныг авч үзвэл итгэлцүүрээр хуваарилах хөрөнгө 1,404.4 сая төгрөг, Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох дэмжлэг 121.3 сая төгрөг, урамшуулал 333.1 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлого, мега төслийн АМНАТ-ын зөрүү 1,515.7 сая төгрөгөөс бүрдэж байна.

Итгэлцүүрээр букуу Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлалаар сумдад хуваарилагдсан хөрөнгө нь харьцангуй жигд байгаа бол олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлого, мега төслийн АМНАТ-ын зөрүү зэрэг нь тухайн сумын ОНХС-ийн үйл ажиллагаа, тухайн нутагт байрлах тусгай зөвшөөрлөөс хамаарч харилцан адилгүй хуваарилагдаж байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3-д заасан олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшууллын дүн нь сумын ОНХС-ийн үйл ажиллагаа түүнд хийсэн үнэлгээнээс шалтгаалж байна.

Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс
2021 онд олгох дэмжлэг, урамшуулал




Эх сурвалж: CTCX-ээс ирүүлсэн судалгаа

Тогтвортой амьжиргаа-3 төслөөс аймгийн 27 сумдын 2020 оны ОНХС-ийн үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн байна. Үнэлгээгээр 2021 оны гүйцэтгэлд суурилсан урамшууллын хэмжээг тогтоожээ. Энэ үнэлгээгээр аймгийн сумдаас Баян сум хамгийн өндөр буюу 80 оноо, улсын хэмжээний 330 сумаас 30-р байранд орсон бол Сүмбэр сум 24 оноо, улсын хэмжээний 330 сумаас 325-р байранд орсон байна. 2020 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 60 онооноос доош оноо авсан Аргалант, Баянхангай, Баянцагаан, Борнуур, Бүрэн, Сүмбэр, Угтаалцайдам зэрэг сумд урамшуулал аваагүй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5-д “Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.6-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно”, 60.6-д “Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно” гэж заасантай холбоотойгоор эдгээр орлогууд нь харилцан адилгүй төлөвлөгдөж, батлагдаж байна. Энэ төрлийн орлого Баянцагаан, Баян, Заамар сумдад өндөр төлөвлөгдөж батлагдаж байгаа бол Зуунмод, Эрдэнэсант, Цээл, Угтаалцайдам, Батсүмбэр, Аргалант сумдад орлого төлөвлөгдөөгүй байна.

Ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл, мега төслийн АМНАТ



Эх сурвалж: СТСХ-ээс ирүүлсэн судалгаа

Дээрх орлогуудаас гадна сумдын ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл 1,918.9 сая төгрөгийг оруулан тооцвол Төв аймгийн 27 сумдын хэмжээгээр 5,293.4 сая төгрөгийн эх үүсвэр хуваарилагдан батлагдсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д аймаг сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг зааж өгсөн. Эдгээрээс 60.2.4-д заасан “татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр” нь орон нутгийн санаачилгаас шалтгаалах орлого юм. Аймгийн хувьд нэмэлт орлогоор 2021 онд 1,050.0 сая төгрөг ОНХС-ийн эх үүсвэрт хуваарилсан бол сумдын хувьд нэмэгдэл эх үүсвэр төлөвлөөгүй байна.

Аймгийн ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл 216.0 сая төгрөг, 27 сумын ОНХС-ын өмнөх оны үлдэгдэл 1,918.9 сая төгрөгийг тус тусын ОНХС-ийн эх үүсвэрт оруулан тооцож баталжээ.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан малын тоо толгойн албан татварын орлогыг 2021 оны ОНХС-ийн төлөвлөлтөд аль ч суманд тооцоогүй байна.

1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг авах ажил холбогдох журмын дагуу хийгдэхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл⁷, 60 дугаар зүйлийн 60.3.6⁸, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн

⁷ Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах

⁸ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дараах нөхцөлүүдийг хангасан байна”, 3.1.2-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх” гэсэн заалтууд нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг иргэд олон нийтийн санал авч дэмжигдсэн байх эрх зүйн үндсийг зохицуулсан. Энэ журмын 5, 6 дугаар зүйлд баг, сумын түвшинд ОНХС-г төлөвлөхөд иргэдийн оролцоог хангах зохицуулалтыг нарийвчлан зааж өгсөн.

Төв аймгийн сумдын хувьд журамд заасан хугацааг баримтлан батлагдсан маягтын дагуу БИНХ хуралдаж, ажлын хэсэг холбогдох аргачлалын дагуу эрэмбэлсэн жагсаалтыг гарган ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд Сангийн яам, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс хэрэгжүүлсэн сургалтын үр дүнд баг, сумын түвшинд ОНХС-г төлөвлөхөд иргэдийн санал авах ажил журмын дагуу хийгддэг болсон байна.

Аймгийн 27 сумын хэмжээнд нийт 19.7 мянган иргэд ОНХС-аар хэрэгжүүлэх ажилд санал өгсөн нь сумдын иргэдийн 21.7 хувь болж байна. ОНХС-г сум, багийн түвшинд төлөвлөхөд иргэдийн оролцоог хангуулах ажил хийгдэж байгаа боловч иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлсэн жагсаалтад багтсан ажлуудыг сумын ИТХ-аар төсөв батлахдаа хасах, оронд нь иргэдийн санал аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй ажлуудыг баталсан байна. Сумдын дүнгээр 13,988.5 сая төгрөгийн 205 ажил эрэмбэлсэн жагсаалтаар гарч ирснээс 3,191.3 сая төгрөгийн 102 ажил ИТХ-аар баталсан төсөвт тусгагдаж, 10,866.4 сая төгрөгийн 102 ажил багтаагүй байна. Сумдын ИТХ-аар 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 5,202.3 сая төгрөгийн 207 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ баталсанд, иргэдээс санал аваагүй 2,011.0 сая төгрөгийн 105 төсөл арга хэмжээ батлагджээ. Энэ нь нийт батлагдсан ажлын 38.6 хувийг эзэлж байна. Жишээлбэл: Батсүмбэр сумын ИТХ 130.0 сая төгрөгийн 2 ажил эрэмбэлсэн жагсаалтаар гарч ирсэн боловч, жагсаалтад огт байхгүй 152.8 сая төгрөгийн 4 ажил баталсан, Баяндэлгэр сумын ИТХ 236.8 сая төгрөгийн 5 ажил эрэмбэлсэн жагсаалтаар гарсан байхад уг жагсаалтад ороогүй 236.8 сая төгрөгийн 9 ажил баталжээ.

Аймгийн Засаг даргын 2020 оны 6 дугаар сарын 09-ны А/352 тоот захирамжаар аймгийн 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг ХОХБТХ⁹-ийн даргаар ахлуулан 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Ажлын хэсэг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг боловсруулан гаргажээ.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 7.3-д “Аймаг, нийслэл нь ОНХС-аас хуваарилсан хөрөнгөөс аймаг, нийслэлд үлдэх хэсэг болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд сум, дүүргийн иргэдээс санал авах зорилгоор энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан санал асуулгын хуудсанд тусгуулан баг, хорооны иргэдээс санал авах үйл ажиллагаатай хамтад нь жил бүр зохион байгуулж болно” гэж заасан хэдий ч аймгийн хувьд иргэдээс саналын хуудсаар санал аваагүй байна. Аймгийн хэвлэл мэдээллийн албаны цахим хуудсаар нийт 147 иргэн цахимаар санал өгсөн, тус иргэдийн саналыг ямар арга замаар төсвийн төсөлд тусгасан нь тодорхойгүй байна.

⁹ ХБТХОХ-ийн тухайн үеийн нэрээр

Журмын 7.5-д урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 7 дугаар сард багтаан 2-оос доошгүй удаа зохион байгуулна гэж заасан хэдий ч ковид-19 цар тахлын улмаас Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах боломжгүй байсан тул хэлэлцүүлэг хийгдээгүй байна.

Мөн түүнчлэн 7.6-д аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хамгийн олон санал авсан, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна гэж заасан боловч энэ ажил хийгдээгүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг боловсруулж гаргасан хэдий ч тус ажлын хэсгийн албан ёсны хурлын тэмдэглэл байхгүйгээс иргэд, сум, байгууллагаас ирүүлсэн саналууд хэрхэн тусгагдсан нь тодорхойгүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн холбогдох заалтын дагуу аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 01 тоот тогтоолоор “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” батлагдсан. Мөн аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 02 тоот тогтоолоор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө тус тус батлагджээ.

Аймгийн ОНХС-аар 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг дээрх хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй харьцуулж үзэхэд нийт 54 арга хэмжээнээс 3-с бусад арга хэмжээ нь уялдсан байна.

Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх зардал 10.0 сая төгрөг, гэр төсөл хэрэгжүүлэх зардал 80.0 сая төгрөг, оюунлаг Төв аймаг хөтөлбөр хэрэгжүүлэх зардал 50.0 сая төгрөг нийт 140.0 сая төгрөгийн хөтөлбөр нь дээрх бодлогын баримт бичигт тусгагдаагүй байна.

Сумдын хувьд сумын Засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээтэй ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээнүүд уялдсан байна.

Төсвийн тухай хуулийн Орон нутгийн чиг үүргийг санхүүжүүлэх гэсэн 58 дугаар зүйлд заасан¹⁰ аймаг, сумын Засаг даргын чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байдлыг судалгаа гаргаж авч үзлээ.

Аймгийн хувьд авч үзвэл 13 чиг үүрэгт хамаарах хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг баталсан байна.

Хүснэгт 3: Аймгийн Засаг даргын чиг үүрэг

| Төсвийн тухай хуулийн заалт | Чиг үүрэг | Төсөл арга хэмжээний | |
|-----------------------------|--|----------------------|---------------|
| | | тоо | дүн /сая.төг/ |
| 58.2.1 | Аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх | 3 | 57.9 |
| 58.2.2 | Хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох | 1 | 12.2 |

¹⁰ Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн

| | | | |
|------------|--|-----------|----------------|
| 58.2.3 | Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх | 31 | 4,308.9 |
| 58.2.8 | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх | 1 | 336.0 |
| 58.2.10 | Усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууц, нийтийн аж ахуй, үерийн хамгаалалтыг зохион байгуулах | 2 | 159.2 |
| 58.2.11 | Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх | 1 | 8.0 |
| 58.2.12 | Мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх | 1 | 362.2 |
| 58.2.14 | Аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох | 4 | 974.8 |
| 58.2.15 | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах | 1 | 430.0 |
| 58.2.16 | Аймгийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | 1 | 100.0 |
| 58.2.18 | Соёлын үйлчилгээ | 2 | 30.0 |
| 58.2.19 | Нийтийн биеийн тамир | 1 | 50.0 |
| 58.2.20 | Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | 6 | 396.1 |
| Дүн | | 55 | 7,225.2 |

Эх сурвалж: СТСХ-ээс ирүүлсэн тайлан

Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх чиг үүрэгт 31 арга хэмжээнд 4,308.9 сая төгрөг баталсан нь нийт батлагдсан төсвийн 59.6 хувийг эзэлж байна.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан¹¹ чиг үүргүүдээс 58.2.4-т “нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах”, 58.2.5-д “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх”, 58.2.6-д “жигжиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх”, 58.2.9-д “малын тэжээлийн нөөц бүрдүүлэх”, 58.2.13-д “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх”, 58.2.17-д “энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын байрлаж байгаа орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт” зэрэг чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг төлөвлөж батлаагүй байна.

Сумдын хувьд 10 чиг үүрэгт хамаарах 2,012.8 сая төгрөгийн 139 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байна. Хуулийн 58 дугаар зүйлийн¹² 58.4.2-д заасан Сумын Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах гэсэн чиг үүрэгт хамаарах арга хэмжээг төлөвлөгдөөгүй байна.

¹¹ Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

¹² Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан

Хүснэгт 4: Сумын Засаг даргын чиг үүрэг

| Төсвийн тухай хуулийн заалт | Чиг үүрэг | Төсөл арга хэмжээний | |
|-----------------------------|--|----------------------|---------------|
| | | тоо | дүн /сая.төг/ |
| 58.4.1 | Сумын удирдлагыг хэрэгжүүлэх | 3 | 18.8 |
| 58.4.3. | Сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалт хийх | 8 | 79.2 |
| 58.4.4 | Мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх | 3 | 22.5 |
| 58.4.5 | Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх | 8 | 140.4 |
| 58.4.6. | Сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах | 2 | 5.8 |
| 58.4.7 | Сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах | 23 | 373.6 |
| 58.4.8 | Сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арчлах | 20 | 315.9 |
| 58.4.9 | Усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх; | 3 | 31.3 |
| 58.4.10 | Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх | 26 | 529.1 |
| 58.4.11 | Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | 43 | 496.2 |
| | ДҮН | 139 | 2,012.8 |

Эх сурвалж: СТСХ-ээс ирүүлсэн тайлан

Баянцагаан сум архивын өрөөний тохижилт, гамшгаас хамгаалах өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, угтах үйлчилгээний танхимын засвар тохижилт зэрэг зардалд 17.0 сая төгрөг, Сэргэлэн сум ЗДТГ-ын авто машины засварт 4.0 сая төгрөг баталсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1-д “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.3.6-д “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, 60.4-д “Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй” гэж заасны тус тус зөрчсөн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан хөрөнгө оруулалтын ажлуудад 5,854.4 сая төгрөгийн 35 барилга байгууламж, авто зам, цахилгаан дулааны эрчим хүч, гүүр хоолойн ажил, их засварын ажлууд батлагдсан байна. Эдгээр ажлууд нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан болон Сангийн сайдын 219 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2, 7.3-д заасан шаардлагын дагуу төлөвлөгдсөн байна.

Бүлэг 2. Аймгийн хэмжээнд 2021 онд ОНХС-аас хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл 62.5 хувьтай байгаагаас сумын гүйцэтгэл 38 хувьтай хэрэгжсэн байна.

2.1 ОНХС-аас хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын захиалагч нь ТБОНӨХБАУХАТ хууль зөрчиж гэрээ байгуулан, хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн 2021 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАУХАТ хуулийн хүрээнд цахимаар буюу tender.gov.mn сайтаар зохион байгуулсан байна. Сумдын хэмжээнд нийт 4,267.9 сая төгрөгийн 186 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс өмнөх оноос шилжсэн 708.1 сая төгрөгийн 41 төсөл арга хэмжээ, шинэ оны 3,559.8 сая төгрөгийн 145 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталсан байна. Үүнээс 627.4 сая төгрөгийн 12 ажлыг нээлттэй тендер, 835.7 сая төгрөгийн 37 ажлыг харьцуулалтын аргаар, 356.4 сая төгрөгийн 46 ажлыг шууд гэрээ байгуулах аргаар, 107.8 сая төгрөгийн 13 ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авалтын аргаар нийт 1,927.4 сая төгрөгийн 108 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. 1,632.4 сая төгрөгийн 37 төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Үнэлгээний хорооны хуралд оролцсон 1 гишүүн хурлын тэмдэглэлд гарын үсэг зураагүй.
- Зуунмод хотын 3-р хэсгийн халаалтын зуухны шинэчлэлийн ажилд үнэлгээний хорооноос захиалагч байгууллагад 2021 оны 7 дугаар сарын 19-ний өдөр “Төв чандмань” ДЭХГ-тай гэрээ байгуулах эрх олгох тухай дүгнэлтийг хүргүүлсэн байна. Захиалагч байгууллага болох “БЗОСК” ОНӨААТҮГ-аас Төв чандмань ДЭХГ-т гэрээ байгуулах эрх олгох тухай 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 366 дугаар албан бичгээр мэдэгдсэн байхад “Төв аймгийн Зуунмод сумын 3-р хэсгийн халаалтын зуухны шинэчлэлийн ажлын зуух түүний тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан байна.
- ЕБС, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг бусад хөрөнгө оруулагч нартай хамтран байгуулахад орон нутгийн оролцоо /7 сум/ төсөл арга хэмжээнд 350.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, НТШ-н аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Эхний тендерт Тантра энерги ХХК, Мөнхзүмбэр ХХК-иуд оролцож, Тантра энерги ХХК-г шалгаруулахад Мөнхзүмбэр ХХК-иас Сангийн яаманд гомдол гаргасан байна. Сангийн яамнаас Мөнхзүмбэр ХХК-ийн гомдлыг үндэслэлтэй гэж үзэж дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргасны дагуу үнэлгээний хороо дахин үнэлгээ хийж тус 2 компанийг шаардлага хангаагүй тендер ирүүлсэн гэх үндэслэлээр татгалзаж, 2 дахь удаагаа НТШ зарлахад Мөнхзүмбэр ХХК-иас тендерийн материал ирүүлсэн байна. Үнэлгээний хороо тус компаний ирүүлсэн тендерийг мөн шаардлага хангаагүй тендер гэж үзэн татгалзаж, захиалагч байгууллагад хэлэлцээр хийх байгууллагын нэр ирүүлэх тухай 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 243 дугаартай албан бичгийг хүргүүлсэн байна. Эхний хэлэлцээрийн урилгыг 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр цахимаар зарлаж, 9 дүгээр сарын 23-ны өдөр нээхэд үнийн санал ирүүлсэн оролцогч байгаагүй тул 9 дүгээр сарын 27-ны өдөр дахин хэлэлцээр хийх урилгыг цахимаар зарлаж 10 дугаар сарын 05-ны өдөр нээхэд Мөнхзүмбэр ХХК-иас үнийн санал ирүүлснийг үнэлж, 10 дугаар сарын 06-ны

өдөр үнэлгээний дүгнэлтийг захиалагч байгууллагад хүргүүлсэн байна. Захиалагч байгууллага нь Мөнхзүмбэр ХХК-д 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 456 дугаар бүхий албан бичгээр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүргүүлсэн байхад тус компанитай “Төв аймгийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг ариун цэврийн байгууламжтай болгох /Эрдэнэ, Баяндэлгэр, Борнуур, Аргалант, Өндөрширээт, Дэлгэрхаан, Баянцагаан/ ажил гүйцэтгэх гэрээг 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан байна. Өөрөөр хэлбэл захиалагч байгууллагаас гэрээ байгуулах эрх олгосон албан бичгийг гүйцэтгэгч компанид хүргүүлэхээс өмнө дээрх 2 ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна.

- Гэр төсөл хэрэгжүүлэх зардалд 80.0 сая төгрөг ИТХ-аар батлагдаж, аймгийн зорилтот өрхийг орон байраар хангах үйл ажиллагааны хүрээнд 40 ширхэг “Гэр” худалдан авах ажлын даалгаврыг аймгийн Засаг даргаар батлуулсан байна. Уг ажлын худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2 удаа зарлаж, сүүлийн тендерт “Мөнхөдбадрах” ХХК 80.0 сая төгрөгийн үнийн санал ирүүлснийг үнэлгээний хорооноос шаардлага хангасан тендер гэж үзэн, шалгаруулж үнэлгээний дүгнэлтийг 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 122 дугаар бүхий албан бичгээр захиалагч байгууллага болох аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн байхад 28 гэрийг 79.8 сая төгрөгөөр худалдаж авахаар Их хүрхрээ ХХК-тай 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр гэрээ байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/607 дугаар захирамжаар аймгийн 2021 онд хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг баталсан байна. Үүнд аймгийн ОНХС-аар хийгдэх 26 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнээс 17 ажлыг нээлттэй төсөл сонгон шалгаруулалтаар, 9 ажлыг харьцуулалтын аргаар худалдан авалт хийхээр төлөвлөгдсөн. 2021 оны 9 дүгээр сарын 08-ны А/543 дугаар захирамжаар шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 5 төсөл арга хэмжээ нэмэгдэж, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөгөөнд нэмэлт оруулжээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 7,225.2 сая төгрөгийн 56 төсөл арга хэмжээг баталснаас өмнө оноос шилжсэн 10 төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтын бус 16 төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтын чанартай шинэ оны 30 төсөл арга хэмжээг баталсны 16 төсөл арга хэмжээг нээлттэй тендер, 10 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 2 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан, 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулагдсан 15 тендерээс 5 тендерийг 2 удаа дахин зарлаж, амжилтгүй болсон тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.4.3-т¹³ заасны дагуу тендер тус бүрд 2-3 удаа хэлэлцээрийн урилга хүргүүлснээр шууд гэрээ байгуулсан байна.

Хөрөнгө оруулалтын чанартай 35 төсөл арга хэмжээний тендерт аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хугацааг баримталсан эсэхийг тулган шалгахад үнэлгээний хороог байгуулахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанаас 56-49 хоногийн өмнө болон 3-207 хоногоор

¹³ энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах.

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн

хэтрүүлсэн, тендер зарлах хугацааг 43-13 хоногийн өмнө болон 8-190 хоногоор хэтрүүлсэн байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар 2021 онд нийт 12,427.5 сая төгрөгийн 263 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар батлагдсаны 7,225.2 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 58 хувийг аймгийн ОНХС эзэлж байна.

Хүснэгт 5: Аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилт /сая.төг/

| № | ОНХС-ийн эх үүсвэр | ИТХ-аар батлагдсан ТАХ | | Гэрээ байгуулсан | | Хэрэгжсэн ТАХ | | | | Хэрэгжээгүй ТАХ | | | |
|---|------------------------------------|------------------------|-----------------|------------------|----------------|---------------|----------------|--------------------|--------------|-----------------|----------------|--------------------|--------------|
| | | Тоо | Санхүүжилт | Тоо | Үнийн дүн | Тоо | Санхүүжилт | Барьцаа ХО дансанд | | Тоо | Санхүүжилт | Барьцаа ХО дансанд | |
| | | | | | | | | Тоо | Санхүүжилт | | | Тоо | Санхүүжилт |
| | Бүгд | 263 | 12,427.5 | 150 | 5,540.5 | 179 | 8,184.7 | 5 | 385.6 | 82 | 3,758.1 | 3 | 609.7 |
| | Үүнээс: Сумын ОНХС | 207 | 5,202.3 | 124 | 1,974.7 | 129 | 2,109.8 | | | 79 | 3,133.4 | | |
| | Аймгийн ОНХС | 56 | 7,225.2 | 26 | 3,565.8 | 50 | 6,074.9 | 5 | 385.6 | 3 | 624.7 | 3 | 609.7 |
| 1 | ХО-ын үлдэгдэл санхүүжилт | 5 | 162.1 | | | 4 | 157.1 | | | | | | |
| 2 | Шилжих барилга | 5 | 1,906.6 | | | 4 | 1,475.6 | 1 | 195.2 | 1 | 399.9 | 1 | 399.9 |
| 3 | Шинээр хийгдэх барилга, байгууламж | 12 | 2,424.0 | 10 | 1,991.6 | 10 | 2,130.9 | 3 | 187.7 | 2 | 224.8 | 1 | 150.0 |
| 4 | Их засвар | 17 | 1,319.2 | 15 | 1,229.1 | 15 | 1,162.0 | 1 | 2.7 | | | 1 | 59.8 |
| 5 | Хөтөлбөр, төсөл арга хэмжээ | 10 | 675.2 | 1 | 345.1 | 10 | 625.1 | | | | | | |
| 6 | Тоног, төхөөрөмж | 3 | 57.9 | | | 3 | 57.5 | | | | | | |
| 7 | Бусад арга хэмжээ | 4 | 680.2 | | | 4 | 466.7 | | | | | | |

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Аймгийн хэмжээнд ОНХС-аас хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл 62.5 хувьтай байгаагаас:

-27 сумын ИТХ-аас 5,202.3 сая төгрөгийн 207 ажил хэрэгжүүлэхээр баталсан боловч 124 ажилд 1,974.7 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 3,133.4 сая төгрөгийн 79 ажил хэрэгжээгүй, гүйцэтгэл 38 хувьтай,

-Аймгийн ОНХС-аас 7,225.2 сая төгрөгийн 56 төсөл, хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас шинээр 30 хөрөнгө оруулалтын ажилд 4,093.2 сая төгрөг /төсөл, арга хэмжээний 1 ажилд 350.0 сая төгрөг/-ийн санхүүжилт батлагдаж, 26 ажилд 3,565.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 624.7 сая төгрөгийн 3 ажил хэрэгжээгүй, гүйцэтгэл 87 хувьтай байна.

Гэрээ байгуулагдаж хэрэгжсэн байдлыг харахад сумын ОНХС-ийн хувьд өндөр өртөгтэй хөрөнгө оруулалтын ажлууд хэрэгжээгүй, бага дүнтэй олон ажил хэрэгжжээ.

Мөн шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлаас гадна урд оны үлдэгдэл санхүүжилт болон он дамжин хэрэгжсэн нийт 16 хөрөнгө оруулалтад 2,371.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас:

-сумын ОНХС-д 6 ажилд 248.7 сая төгрөг батлагдаж санхүүжилт бүрэн олгогдсон,

-аймгийн ОНХС-д 10 ажилд 2,068.7 сая төгрөг батлагдаж 8 ажилд 1,632.7 сая төгрөгийн санхүүжилт хийгджээ.

Үүнээс гадна аймгийн ОНХС-аас хөрөнгө оруулалтын бус 16 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 1,068.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, 804.2 сая төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

Хүснэгт 6: Аймаг, сумын ОНХС-аар хэрэгжиж гэрээ байгуулагдсан хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

/сая.төг/

| № | ОНХС-ийн эх үүсвэр | Гэрээ байгуулсан | | Хэрэгжсэн хөрөнгө оруулалт | | | | | |
|---|------------------------------------|------------------|----------------|----------------------------|----------------|-----------------|----------------|-----------------|---------------|
| | | Тоо | Үнийн дүн | Бүгд | | Бүрэн хэрэгжсэн | | Дутуу хэрэгжсэн | |
| | | | | Тоо | Гэрээний дүн | Тоо | Гэрээний дүн | Тоо | Гэрээний дүн |
| | Бүгд | 150 | 5,540.5 | 159 | 7,223.4 | 152 | 6,272.0 | 7 | 1040.6 |
| | Үүнээс: Сумын ОНХС | 124 | 1,974.7 | 129 | 2,109.8 | 124 | 1,955.2 | 5 | 154.6 |
| | Аймгийн ОНХС | 26 | 3,565.8 | 30 | 5,113.6 | 28 | 4,316.8 | 2 | 886.0 |
| 1 | Шилжих барилга | | | 4 | 1,475.6 | 3 | 961.2 | 1 | 550.0 |
| 2 | Шинээр хийгдэх барилга, байгууламж | 10 | 1,991.6 | 10 | 2,130.9 | 9 | 1,781.4 | 1 | 336.0 |
| 3 | Их засвар | 15 | 1,229.1 | 15 | 1,162.0 | 15 | 1,229.1 | | |
| 4 | Хөтөлбөр, төсөл арга хэмжээ | 1 | 345.1 | 1 | 345.1 | 1 | 345.1 | | |

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Аймаг, сумдын ОНХС-аас нийт 150 хөрөнгө оруулалтад 5,540.5 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 6,272.0 сая төгрөгийн 152 ажил бүрэн, 1,040.6 сая төгрөгийн 7 ажил дутуу хэрэгжсэн байна.

Тайлант оны эцэст аймгийн ОНХС-аас дутуу буюу хэрэгжээгүй 8 хөрөнгө оруулалтын 995.3 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийг дансанд байршуулсан байна. Тухайлбал:

- Хэрэгжилт дутуу 5 ажлын 385.6 сая төгрөг,
- Гэрээ байгуулсан боловч хэрэгжээгүй 3 ажлын 609.8 сая төгрөг байна.

Мөн зарим сумд ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчил илэрлээ. Үүнд:

- Дэлгэрхаан суманд 43.4 сая төгрөгөөр гудамж төсөлд сумын төвийн гэр хорооллын айл өрхийн хашааг тохижуулах хашааны банз худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4-т “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчжээ.
- Сэргэлэн суманд ЗДТГ-ын авто машины засварт 4.0 сая төгрөгийн санхүүжилт баталсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1-т “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.4-д “Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй” гэсэн заалтыг тус тус зөрчсөн. Энэ зөрчилд СХДАА-наас төлбөрийн акт тавьсан байна.
- Баянцагаан сум ОНХС-ийн хөрөнгөөр гамшгаас хамгаалах өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 7.0 сая төгрөг баталж, улмаар ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данс руу шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1-т “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.4-д “Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг,

нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй” гэснийг зөрчсөн тул төлбөрийн акт тавьсан.

Үүнээс гадна ОНХС-ийн хөрөнгөөр гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэхдээ Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.2.6-д “Захиалагч нь барилгын ажлын зардал, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа /цаашид “ТЭЗУС” гэх/, техник, эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/, зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материал, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Алтанбулаг сумын 1 ажлын 3.5 сая төгрөгийн, Баянжаргалан сумын 3 ажлын 3.7 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг гүйцэтгэгчид шилжүүлж, илүү санхүүжилт олгосон нь ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.2. Аймгийн хэмжээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжлийн бодлого болон иргэдийн саналаар эрэмбэлэгдэж, хэрэгжиж байгаа нь тухайн орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлж байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжихээр батлагдаж гэрээ байгуулагдсан зарим төсөл арга хэмжээ гэрээний хугацаа хэтэрсэн, комиссын актаар хүлээн авч ашиглалтад оруулаагүй байгаа нь тухайн төсөл, арга хэмжээний зорилтод түвшин, үр дүнг бууруулж байна. Үүнд: Архуст сумын 12.0 сая төгрөгийн мал угаалгын ванн, Батсүмбэр сумын 63.3 сая төгрөгийн явган хүний замын ажил, Баяндэлгэр сумын 18.8 сая төгрөгийн хүүхэд залуучуудын чөлөөт цаг өнгөрүүлэх тоног төхөөрөмж, аймгийн ОНХС-аас хэрэгжиж байгаа 994.7 сая төгрөгийн “10 ортой Эрүүл мэндийн төвийн барилга барих /Баян өнжүүл сум/” ажил.

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжлийн бодлого болон иргэдийн саналаар эрэмбэлэгдэж, хэрэгжиж байгаа нь тухайн орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлж байна. Эдгээр ажлуудаас жил бүр 26 суманд худаг гаргах ажилд 200.0-300.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, хэрэгждэг боловч үр өгөөжийг хүртэгч нь тодорхой бус, сумын хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч тухайн хөрөнгө хадгалалт, хамгаалалтгүй байна.

2.3. Хөрөнгө оруулалтын ажил нь хугацаандаа хэрэгжээгүйгээс үр дүн, үр өгөөжгүй болж, тухайн ажилд зарцуулсан санхүүжилтийн үр дүнд бий болсон хөрөнгө эвдэрч муудан, ашиглалтгүй болж байна.

ОНХС-аас хэрэгжсэн зарим барилга байгууламж олон жил хэрэгжиж, хугацаандаа ашиглалтад ороогүйгээс тухайн хөрөнгө оруулалтын ажил үр дүн, үр өгөөжгүй болж, хөрөнгө муудах, эвдрэх, алдагдах зэрэг нөхцөл байдал бий болсон байна. Тухайлбал: Баянжаргалан суманд 2018 онд хэрэгжсэн 56.1 сая төгрөгийн гэрээтэй мал нядалгааны цехийн барилга тухайн онд буюу гэрээний хугацаанд, 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар ашиглалтад ороогүй байна. Тухайн ажилд 43.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд хугацаандаа ашиглалтад ороогүйгээс тухайн хөрөнгө эзэнгүйдэж, эвдэрч хэмхрэн дахин ашиглах боломжгүй болсон байна.

Бүлэг 3. ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд мэдээлэл оруулах ажил хангалтгүй, түүнд тавих хяналт байхгүй байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад СХДАА-аас жил бүр хяналт тавьж ажилласан байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам /өмнөх 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд энэ заалт мөн энэ хэвээрээ байсан/-ын 9.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина” гэж заасан.

Аймгийн ИТХ-ын хороодын 2021 оны төлөвлөгөөнд ОНХС-ийн зарцуулалтад тавих хяналт шалгалтын ажил батлагдаагүй энэ чиглэлийн хяналт хийгдээгүй байна.

Сумдын хувьд албан бичиг хүргүүлж сумын ИТХ-аас ОНХС-нд хийгдсэн хяналт шалгалтын материалыг авч үзэхэд доорх 3 сумд хяналт шалгалтын ажил хийжээ.

Эрдэнэсант сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 03 тоот тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэй ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт хийх хороо байгуулсан байна. Тус хороо 3 чиглэлээр хяналт хэрэгжүүлж 2021 оны 10 дугаар сард ИТХ-д танилцуулан ажиллажээ.

Баянцогт сумын ИТХ 3 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын зөвлөл байгуулж, тус хяналтын зөвлөл нь 2021 онд ОНХС-аар хэрэгжсэн 5 ажилд хяналт хийн дүгнэлт, зөвлөмж гарган сумын ИТХ-д танилцуулсан байна.

Лүн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 38 тоот тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн явц, үр дүнд хяналт шалгалт хийх хяналтын хороо 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна. Тус хороо 2021 оны 5 дугаар сарын 25-нд хогийн цэг түрж булах ажилд, 6 дугаар сарын 20, 25, 7 дугаар сарын 7-нд соёлын төвийн цахилгааны их засварын ажилд, 7 дугаар сарын 8, 8 дугаар сарын 05-нд мал угаалгын банн хийх ажилд тус тус хяналт шалгалт хийж дүгнэлт гарган фото зургаар баримтжуулан ажилласан байна.

Бусад сумдын ИТХ-аас ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн баримт материал ирүүлээгүйгээс үзэхэд журмын заалтын ИТХ-тай холбоотой хэсгийн хэрэгжилт хангалтгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлэхдээ батлагдсан санхүүжилтэд багтаан хэрэгжүүлснээр зайлшгүй тооцогдох ёстой зардлууд хасагдаж, тухайн хөрөнгө оруулалтын ажлын үр өгөөж, үр дүн бодит бус болсон байна. Тухайлбал: Эрдэнэ сум 2 ажлын шууд зардлаар буюу төсөвт өртөгт зайлшгүй тооцогдох ёстой зураг төсөв, захиалагч болон зохиогчийн хяналт, магадалшгүй ажлын зардлуудыг оруулж тооцоогүй төсвөөр ХАА

зохион байгуулж, 89.9 сая төгрөгийн гэрээ байгуулан, ажил гүйцэтгүүлсэн нь тухайн ажлын гүйцэтгэлд тавих хяналт хийгдээгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ОНХС-ийн батлагдсан төсвийн хуваарь, төлөвлөсөн зардлын санхүүжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийн гаргалт, болон анхан шатны баримт бүрдүүлэлтийн байдалд хяналт шалгалт хийсэн байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн хүрээнд 27 сумдын ОНХС-д эрсдэлийн үнэлгээ хийхэд 16 сум 85-100 хувь буюу бүрэн хэрэгжсэн, 9 сум 70-84 хувь буюу дунд хэрэгжсэн, 2 сум 69-с доош буюу хангалтгүй хэрэгжсэн гэсэн үнэлгээтэй гарчээ. 5 сумтай холбоотой 8.2 сая төгрөгийн акт тавигдаж, 11 сумтай холбоотой 277.6 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж 8 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

3.2. Аймгийн ХОХБТХ-т сумдын ЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг ирүүлж нэгтгүүлэн Сангийн яаманд хүргүүлэх ажил хэрэгжихгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.1-д “дүүргийн төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн алба нь ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 10 дугаар хавсралтын дагуу аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах хугацаанд тайлагнана” гэж заасан. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-т аймгийн 27 сумын санхүүгийн албанаас журмын 10 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу тайлан ирүүлсэн байна.

Дээрх журмын 9.2-д “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана” гэж заасан. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т сумдаас ирүүлсэн тайланг авч үзэхэд Жаргалант, Баянжаргалан, Цээл, Баянцогт гэсэн 4 сумд тайлан ирүүлжээ. Бусад 23 сумд цаасаар тайлан ирүүлээгүй байна.

Ирүүлсэн 4 сумын тайлан нь янз бүрийн загвар, форматтай журмын 9.9-д заасан мэдээллийг бүрэн тусгаагүй байна. Тухайлбал:

- Жаргалант, Цээл сумдаас журмыг хавсралт 10-р маягтаар /СТСХ-д өгсөн/ тайлангаа ирүүлсэн,
- Баянжаргалан сум ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажил, хэрэгжилт гэсэн үзүүлэлтээр,

Баянцогт сум хийгдэх ажил, оны эхний үлдэгдэл, санхүүжилт, батлагдсан төсөв, гүйцэтгэсэн гэрээний дүн, үлдэгдэл санхүүжилт, биелэлт, тайлбар гэсэн үзүүлэлтээр ОНХС-аас хийгдсэн ажлын тайлан гэж тус тус ирүүлсэн байна

Журмын 9.9-д “аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн

асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх...” гэсэн заалт хэрэгжихгүй байна. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн холбогдох албан тушаалтнууд удирдлага мэдээллийн системээр тайланг Сангийн яаманд хүргүүлсэн гэх боловч сумдын тайланг хэрхэн нэгтгэсэн, тогтоосон хугацаанд аймгийн хэмжээний мэдээллийг бүрэн гүйцэд явуулсан нь эсэх нь тодорхойгүй байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 6,331.3 сая төгрөгийн 150 хөрөнгө оруулалтын ажил бүрэн хэрэгжиж, комиссын актаар хүлээн авч ашиглалтад оруулсан байна. Үүнд:

- Сумдын ОНХС-аас 2,077.2 сая төгрөгийн 122 хөрөнгө,
- Аймгийн ОНХС-аас 4,254.1 сая төгрөгийн 28 хөрөнгө бий болсон байна.

Үүнээс сумдын ОНХС-аас бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаж, аймгийн ОНХС-аас хэрэгжсэн 1,597.6 сая төгрөгийн 9 хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлд ОНХС-ын удирдлага мэдээллийн системийн талаарх зохицуулалтыг тусгасан. Журмын 10.2, 10.3-д заасан хугацаанд, заасан мэдээллийг оруулсан эсэх, түүнд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна.

Сангийн яамны хэрэгжүүлсэн onhs.mof.gov.mn системд аймаг, сумдын 2021 онд оруулсан мэдээллийг бодит гүйцэтгэлтэй тулгахад ихээхэн зөрүүтэй байна. Тухайлбал:

- Батлагдсан төсөв 2,596.3 сая төгрөгөөр дутуу
- Санхүүжилт 5,681.4 сая төгрөгөөр дутуу
- Гэрээний дүн 4,688.4 сая төгрөгөөр дутуу
- Зарцуулалт 6,646.8 сая төгрөгөөр дутуу
- Гүйцэтгэгчид олгосон санхүүжилт 6,692.2 сая төгрөгөөр дутуу
- Санал өгсөн иргэдийн тоо 138,421 хүнээр илүү мэдээлэгдсэн байна.

Эндээс үзэхэд журмын 10 дугаар зүйлд заасан удирдлага мэдээллийн системээс үнэн зөв мэдээлэл авах боломжгүй байна.

Журмын 10.3.3-д “ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар сар бүр болон бүтэн жилээр мэдээлэх 13 мэдээ байна. Төв аймгийн 27 сум, аймгийн хэмжээнд нийт 364 мэдээ оруулахаас 320 мэдээ байршуулсан байна. Үүнээс 44 мэдээлэл хугацаа хоцроосон, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө бүтэн жилээр, худалдан авах ажиллагааны тайлан бүтэн жилээр, сум тус бүр 2 мэдээ, нийт 56 мэдээлэл оруулахаас 40 мэдээг хугацаандаа мэдээлсэн, 14 мэдээг хугацаа хоцроосон, 2 мэдээг огт мэдээлээгүй байна.

Тус аудитаар илэрсэн зөрчилд нийт 14.2 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 3,595.7 сая төгрөгийн 10 албан шаардлага, 33,530.3 сая төгрөгийн 2 зөвлөмж бичигдлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Аймгийн ОНХС-аас сумдын ОХНС-нд олгох шилжүүлгийн тооцооллыг Сангийн яамнаас тооцож ирүүлсний дагуу баталж, хуваарийн дагуу олгож байна.
- Сумдын хувьд 2021 оны ОНХС-ийн эх үүсвэрт хуульд заасан татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, малын тоо толгойн албан татварыг огт төлөвлөөгүй байна.
- Сумдын хувьд журамд заасан хугацааг баримтлан батлагдсан маягтын дагуу БИНХ хуралдаж, ажлын хэсэг холбогдох аргачлалын дагуу эрэмбэлсэн жагсаалтыг гаргаж байгаа боловч сумын ИТХ-аар ОНХС-ийн төсөв батлахдаа иргэдээс санал аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй ажлуудыг баталж байгаа нь Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын холбогдох заалтуудыг зөрчиж байна.
- Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг боловсруулж гаргасан хэдий ч тус ажлын хэсгийн албан ёсны хурлын тэмдэглэл байхгүйгээс иргэд, сум, байгууллагаас ирүүлсэн саналууд хэрхэн тусгагдсан нь тодорхойгүй байна.
- Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас жил бүр сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж байна.
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.9-д Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ гэж заасныг хэрэгжүүлэхгүй байна.
- Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв оруулсан эсэхэд тавих хяналтын тогтолцоо байхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Ю.Бямбацогт нарт зөвлөх нь:

- Аймгийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөхдөө Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж, иргэд олон нийтийн өгсөн саналыг хөрөнгө, оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад тусгах талаар арга хэмжээ авч ажиллах.
- “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлд заасан ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв мэдээлэх, хяналт тавьж ажиллах.

Сумдын Засаг дарга нарт зөвлөх нь:

- Сумдын ОНХС-ийн эх үүсвэрт хуульд заасан малын тоо толгойн албан татварыг тооцон төлөвлөж, хэрэгжүүлэх

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор

Ц.Хишигжаргал

Аудитын менежер

О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор

Л.Жаргалсайхан

Аудитор

Ч.Загдсүрэн

Аудитор

Г.Сугармаа

Аудитор

Б.Нямсүрэн

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



Тус тайлангийн төсөлд санал авахаар 3 байгууллагад хүргүүлснээс аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс санал ирээгүй, 2 байгууллагаас тайлангийн төсөлтэй танилцсан, дүгнэлтэд тусгах саналгүй тухай албан бичгээр мэдэгдсэн байна.


**ТӨВ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**
41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70273539, Факс: 70273579
2022.06.08 № 168
тантай _____ -ны № _____ -г
**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийгдсэн дүгнэлттэй танилцлаа.

Аудитын санал, дүгнэлтэд тусгах саналгүй болно.

ДАРГА

Д. БАТЖАРГАЛ



**ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

41111, Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273623 Факс: 70272237

2022.06.04 № 05/1042
танай _____ -ны № _____ -г

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжтэй танилцав.

Аудитын тайлангаар өгөгдсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА _____ Ю.БЯМБАЦОГТ



4192021057

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2-р байр
Утас: +976 70272582, +976 70272287
И-мэйл: tuv@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn